



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 07 сарын 27 өдөр

Дугаар 237

Улаанбаатар хот

“Мобифинанс ББСБ” ХХК-д банк бус
санхүүгийн төлбөр тооцооны хэрэгсэл гаргах
тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мобифинанс ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн төлбөр тооцооны хэрэгсэл гаргах тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, холбогдох өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газарт бүртгүүлэхийг “Мобифинанс ББСБ” ХХК /Ц.Сэргэлэн/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
ДЭД ДАРГА



Э.БАТБОЛД